



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/444

Булган сум

“Англи хэлтэй Булган” хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, “Англи хэлтэй Булган хөтөлбөр батлах тухай” VI/33 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зардал батлах тухай” А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх “Англи хэлтэй Булган” хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагааг 2025 оны 06 дугаар сарын 02-нд зохион байгуулсугай.

2. Нээлтийн үйл ажиллагааны удирдамжийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Нээлтийн үйл ажиллагаанд зарцуулагдах 1,581,000 (нэг сая таван зуун наян нэгэн мянга) төгрөгийг “Англи хэлтэй Булган” хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас тус тус санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д. ПҮРЭВ-ОЧИР



6325010809

Аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар
сарын 25 ыг өдрийн 1 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

“АНГЛИ ХЭЛТЭЙ БУЛГАН” ХӨТӨЛБӨРИЙН НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

ҮНДЭСЛЭЛ:

“Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны VI/33 дугаар тогтоолоор “АНГЛИ ХЭЛТЭЙ БУЛГАН” хөтөлбөрийг батлаад байна.

Дээрх хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш, сурагчид, иргэд, төрийн албан хаагчдыг мэдээллээр хангаж, оролцоог сайжруулах нь чухал болоод байна.

ЗОРИЛГО:

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх “Англи хэлтэй Булган” хөтөлбөрийн талаарх мэдээллийг ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш, сурагчид, иргэд, төрийн албан хаагчдад хүргэх

ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА:

1. Үйл ажиллагаанд оролцогчид
 - Боловсролын газар,
 - Ерөнхий боловсролын сургууль
 - Төрийн байгууллагууд
 - Худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж, ахуй нэгж
 - Булган сумын иргэд
2. Хөтөлбөрүүдийн нээлтийн үйл ажиллагааг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдана.

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

1. “Англи хэлтэй Булган” хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагааны хүрээнд:
 - Хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнг иргэдэд танилцуулна.
 - Монголын Англи хэлний академтай хамтран “Англи хэлийг яаж хурдан сурах вэ?”, “Англи хэл ба тэтгэлэгт хамрагдах боломж” зэрэг сэдвээр ЕБС-ийн захирал, менежер, англи хэлний багш нар, ахлах ангийн сурагчид, сумын удирдлагуудад сургалт зохион байгуулна.
 - Монголын Англи хэлний академтай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулна.
 - “Англи хэлний 7000 үг” номын танилцуулга, сурталчилгааг хийнэ.

Аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар
сарын 25-ыг өдрийн 1 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

**“АНГЛИ ХЭЛТЭЙ БУЛГАН” ХӨТӨЛБӨРИЙН НЭЭЛТИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ**

№	Шаардлагатай зардал	Хэмжих нэгж	Тоо	Үнэ (төгрөг)	
				Нэг бүр	Нийт
1	Хоолны зардал	Ширхэг	33	16,545	546,000
2	Англи хэлний академийн сургагч багш нарын зочид буудлын зардал	Хүн.хоног	4	55,000	220,000
3	Кофе	Ширхэг	4	15,000	60,000
4	Гарын бэлэг	Ширхэг	5	91,000	455,000
5	Хэвлэлийн эх бэлтгэл	Багц	1	300,000	300,000
	Нийт				1,581,000